



## АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ГҮЙЦЭТГЭГЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ДҮГНЭЖ, ХАРИУЦЛАГЫН  
ТОГТОЛЦООГ ХЭВШҮҮЛЭХ НЬ ЗҮЙТЭЙ БАЙНА.

Аудитын тайланг  
бэлтгэсэн:

ҮАГ-ын харъяа  
Архангай аймгийн  
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх  
аудитор

Д.Уламбаяр

Утас: 70332141

Аудитын менежер

Т.Байгалмаа

Утас: 70332860

Ахлах аудитор

Д.Нэргүйбаатар

Утас: 70333019

Аудитор

Г.Цог-эрдэнэ

**Уг тайланг ҮАГ-ын  
Веб сайт-аас үзнэ үү.**

2018 оны 05 дугаар  
сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70332860 дугаар утас,  
70332141 дугаарын  
факсаар харилцана уу.

Хаяг: Архангай аймаг,  
Эрдэнэбулган сум, 3-р  
баг, аймгийн ЗДТГ-ын  
байр, А корпус, 3-р  
давхар 311 тоот өрөө

АГУУЛГА

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

**Бүлэг 1. Урт болон дунд хугацааны төлөвлөгөөг үндэслэн  
төлөвлөсөн боловч эрх шилжүүлэх хугацаа алдсанаас  
зарим ТАХ он дамжин хэрэгжиж байна.**

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг урт болон дунд  
хугацааны мөрийн хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.

1.2. Шаардлагатай ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл  
арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

1.3. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл бүрэн хангагдаагүй  
буюу эрх шилжүүлэхдээ хугацаа алдсанаас зарим ТАХ он  
дамжин хэрэгжихэд хүрсэн байна.

**Бүлэг 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим арга  
хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.**

2.1. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын  
дагуу зохион байгуулсан байна.

2.2. Төсөл арга хэмжээний зураг төсвийг холбогдох хууль  
журмын дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

2.3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд хэрэгжүүлээгүйгээс  
ТАХ-ний ашиглалтанд орох хугацаа хоцорсон байна.

2.4. Захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж  
хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аваагүй байна.

2.5. Бүрэн хэрэгжиж ашиглалтанд ороогүй ТАХ-ний  
санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

**Бүлэг 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн  
зарим арга хэмжээг ашиглаж эхлээгүй байгаа нь бодит үр  
өгөөж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, хүртэх үр дүн, үр  
ашиг хүлээгдсээр байна.**

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх  
зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн төсөл  
арга хэмжээний хэрэгжилтэнд аймгийн Засаг даргын  
дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба болон ЗДТГ-аас  
хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.3. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга  
хэмжээний хэрэгжилт удааширснаас ашиглалтанд орох  
хугацаа хойшилж, хүртэх үр дүн үр ашиг хүлээгдсээр байна.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.**

**Дүгнэлт**

**Зөвлөмж**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|               |                                                                                           |
|---------------|-------------------------------------------------------------------------------------------|
| ААГ           | АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР                                                            |
| ҮАГ           | ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР                                                                    |
| ГА            | ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ                                                                        |
| ИТХ           | ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ                                                              |
| УИХ           | УЛСЫН ИХ ХУРАЛ                                                                            |
| ТЕЗ           | ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ                                                               |
| ЗДТГ          | ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР                                                                 |
| ХОХБТХ        | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС                                      |
| СТСХ          | САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС                                                              |
| ГХБХБГ        | ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР                                            |
| ОНӨГ          | ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР                                                                 |
| ИТХТ          | ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД                                                |
| АДБОУС        | АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ                                          |
| ЭМТ           | ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ                                                                         |
| ХАА           | ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА                                                                   |
| ТБОНӨХБАҮХАТХ | ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ |
| БХБС          | БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД                                                             |
| БСШУСС        | БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД                                                |
| ЗГХЭГ         | ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР                                                         |
| ЭМС           | ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД                                                                        |
| ТАХ           | ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ                                                                         |
| ХХК           | ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ                                                      |

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Аудитын хамарсан хүрээ, арга зүй

**Аудитын нэр:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

**Аудитын код:** УАГ-ГАГ/2018/01-ГА

### **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Их хурлын төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ болон Архангай аймаг дахь Төрийн Аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн Аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

### **Аудитын зорилт:**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлэн 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, тайланг УАГ-т хүргүүлэх болон орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож үнэлсэн эсэх

### **Аудитын хамрах хүрээ:**

Аудитаар орон нутгийн ТЭЗ-д эрх шилжүүлэн 2017 онд улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, аймгийн ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох сумын ЗДТГ-ыг хамруулан шалгалаа. Мөн аймгийн төв болон суманд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт, гүйцэтгэлийг түүвэрлэн газар дээр нь үзэж танилцлаа.

**Үндсэн мэдээлэл:**

Архангай аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 18 төсөл, арга хэмжээнд Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 11 сарын 04-ны өдрийн хуульд улсын төсвийн хөрөнгөөс 2,118.99 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан байна. Үүнд:

Их засварын 1,371.99 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй 13 ажил, 10.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах 1 арга хэмжээ, он дамжин хэрэгжиж буй 736.2 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 4 ажлыг холбогдох ТЕЗ нараас орон нутгийн ТЕЗ-д эрх шилжүүлэн санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна.

Их засвар:

- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдаас 990.19 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ,
- Эрүүл мэндийн сайдаас 381.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ,

Тоног төхөөрөмж худалдан авах:

- Сумын ЭМТ-ийн багийн эмч нарт мотоцикл худалдан авах 10.8 сая төгрөг

Он дамжин хэрэгжих ТАХ,

- Хангай сумын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга 2017 онд санхүүжих дүн 94.7 сая төгрөг,
- Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох /Эрчим хороолол 76 айл/ ажил гэрээний үнэ 797.9 сая төгрөг, 2017 онд санхүүжүүлэх дүн 169.9 сая төгрөг,
- Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл” инженерийн шугам сүлжээний ажил гэрээний үнэ 4794.0 сая төгрөг, 2017 онд санхүүжих 338.4 сая төгрөг,
- Хашаат сумын ЗДТГ-ын барилга угсралтын ажил гэрээний үнэ 943.2 сая төгрөг, 2017 онд санхүүжих 133.2 сая төгрөг,

Дээрх хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 51.2 хувийг боловсрол, соёлын салбарт 24.0 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 18.5 хувийг эрүүл мэндийн салбарт, 6.3 хувийг ЗГХЭГ буюу удирдлагын салбарт зарцуулахаар төлөвлөсөн байна.

Эрх шилжүүлээгүй боловч Архангай аймагт 2017 онд хэрэгжихээр хуулиар батлагдсан дараах төсөл арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Архангай аймгийн Хөгжимт драмын театрын барилга угсралтын ажил
- Төвшрүүлэх сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн спорт залны барилга
- Эрдэнэмандал сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралт
- Хүүхэд залуучуудын соёл спортын төв, усан бассейн
- Тэрхийн голын төмөр бетон гүүрний засварын ажил

### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтг элийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа, тайлбар авах, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, давтан тооцоолох, анхан шатны баримтаас хөөн шалгах, бодитоор оршин байгаа эсэхийг үзэх буюу ажиглах, баримтжуулах зэрэг аудитын арга зүйн горимуудыг ашиглав.

### **Аудитын шалгуур:**

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Иргэний хууль
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”
- Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор Г.Цог-эрдэнэ нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

### **Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ .

Аудитын тайланд аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах бүх нотлох зүйл, мэдээллийг хангалттай зохистой хэмжээгээр оруулсан болно.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулан саналыг авч, аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан эцсийн байдлаар ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшиний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА АЛДСАНААС ЗАРИМ ТАХ ОН ДАМЖИН ХЭРЭГЖИХЭД ХҮРСЭН БАЙНА.**

**1.1. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ нь нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.**

- *Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг урт болон дунд хугацааны мөрийн хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.*

#### Улсын төсвийн хөрөнгө оруулалт



Архангай аймагт 2017 онд 1,315.8 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй 13 их засварын ажил, 10.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мотоцикл худалдан авах 1 арга хэмжээ, он дамжин хэрэгжих 736.2 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 4 ажлыг холбогдох ТЕЗ нараас аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлжээ. Үүнээс 6 сум, аймгийн төвд хэрэгжсэн 9 ажлын гүйцэтгэл, чанар, ашиглалтын байдлыг аудитаар шалгалаа. Мөн эрх шилжээгүй боловч аймагт хэрэгжүүлсэн 2017

онд 4,220.5 сая төгрөгөөр санхүүжих дүн бүхий 4 арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг газар дээр нь үзэж танилцан фото зургаар баримтжууллаа.

Үүнээс шинээр хэрэгжүүлэхээр ТЕЗ нараас эрх шилжүүлсэн ТАХ-үүд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", Төсвийн тухай хуулийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу аймгийн ТЕЗ-аас Сангийн яаманд хүргүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгагдсан эсэхийг тулган шалгалаа. Эрх шилжүүлсэн ТАХ-ний дэлгэрэнгүйг Хавсралт №1-ээс үзнэ үү.

Үүнд:

- Эрүүл мэндийн сайдаас эрх шилжүүлсэн “Төрөх эмнэлгийн их засвар”, “Хотонт, Хангай сумын ЭМТ-ийн нам даралтын зуух шинэчлэх, Өндөр-Улаан сумын ЭМТ-ийн дулааны шугамын засвар”-ын ажил нь Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 4.5.1 “эмнэлэг, лабораторийн тоног төхөөрөмжийн байнгын нийлүүлэлт, засвар үйлчилгээг хангах тогтолцоо бий болгож, оношилгооны чадавхийг сайжруулах”,
- Боловсролын сайдаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлууд нь Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 4.4.1. “хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж, хэмжээ, байршлыг оновчтой болгосон цэцэрлэг, сургуулийн зураглалыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай А1 нийцсэн байна.

Түүнчлэн дээрх хөрөнгө оруулалтын ТАХ-үүд нь Төсвийн тухай хуулийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу аймгийн Засаг даргаас 2016 оны 08 сарын 10 өдрийн 01/839 тоот албан бичгээр Монгол Улсын ерөнхий сайд, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Сангийн яаманд хүргүүлсэн Архангай аймагт 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтанд тусгагдсан байна.

- *Шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.*

Тухайлбал:

- Батцэнгэл сумын сургууль нь 1976 онд ашиглалтанд орсон. Сүүлийн жилүүдэд дээврээс их хэмжээний ус дотогш гоожсоноос сургалтын үйл ажиллагаанд хүндрэл учруулах болсон байна. Иймд зайлшгүй шаардлагаар сургуулийн дээврийн төмрийг 100% солих болон хаалга шинээр солих, шал, ханын ажил зэрэг дотор их засварын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.
- Өлзийт сумын сургуулийн спорт заалны модон шал цөмөрч сургалтын үйл ажиллагаанд хүндрэл учруулж ирсэн байна. Иймд тус спорт заалны шалыг 100 хувь солих зайлшгүй шаардлагаар их засварын ажлыг төлөвлөжээ.
- Төвшрүүлэх сумын хүүхдийн цэцэрлэгийн халаалтын тогооны барилга нь стандартын шаардлага хангахгүй, хүчин чадал нь бүх танхимыг халаахад хүрэлцэхгүйн улмаас өвлийн улиралд сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх болсон байна. Иймд халаалтын тогоо, шугам сүлжээг шинэчилж, халаалтын тогооны барилгыг шинээр барихаар төлөвлөсөн байна.

#### **1.2. Шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.**

- *Хөрөнгө оруулалтын жагсаалтанд нэр, хэрэгжих хугацаа, тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж батлаагүй байна.*

- *Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд шинээр барилга байгууламжийн ажил эхлээгүй бөгөөд бусад их засварын ажлууд нь газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл авах шаардлагагүй байна.*
- *Эрх шилжүүлсэн ТАХ-нд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй.*
- *Он дамжин хэрэгжиж буй ТАХ-ний зураг төсөв, санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна.*

Орон нутагт **эрх шилжүүлсэн өмнөх оноос он дамжин** хэрэгжиж буй Эрчим хорооллын 76 айлын цэвэр бохир усны шугам, Хангай сумын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга, Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл”, Хашаат сумын ЗДТГ-ын барилга гэсэн 4 арга хэмжээ байгаа бөгөөд энэ 4 ажлын төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.

**1.3. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл бүрэн хангагдаагүй буюу эрх шилжүүлэхдээ хугацаа алдсанаас зарим ТАХ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.**

- *Төсөл арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан тооцож батлуулсан байна.*

2017 онд шинээр хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ТАХ-үүд нь хуульд ерөнхий нэрээр тусгагдсан байна. Тухайлбал: Төсвийн тухай хуулийн XVI.2.1-д “Эрүүл мэндийн салбарын их засвар улсын хэмжээнд”, XII.1.2.1-д “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын барилга байгууламжийн өргөтгөл, их засвар /улсын хэмжээнд/” гэж тус тус заажээ. Эрх шилжүүлсэн ТЕЗ-ийн тушаалаар баталсан нэр, байршлыг өөрчилж хэрэгжүүлсэн зөрчил илрээгүй. Тухайлбал: ЭМС-ын 2017.01.23-ны А/35 тушаалаар баталсан жагсаалтанд 50 ортой төрөх эмнэлгийн их засвар, 2017.11.14-ний А/433 тушаалаар баталсан “Өндөр-Улаан сумын ЭМТ-ийн дулааны шугам, Хотонт, Хангай сумын ЭМТ-ийн нам даралтын зуух шинэчлэх”, БСШУС-ын сайдын 2017 оны А/82, А/110, А/173, А/145 тушаалаар эрх шилжүүлсэн арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.

- *ТАХ-ний хэрэгжүүлэх эрхийг орон нутагт шилжүүлэхдээ хугацаа алдсанаас тендер шалгаруулалт оройтож, төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.*

БСШУССайдаас “Жаргалант сумын 75 ортой дотуур байрны барилгын шугам сүлжээ, халаалтын тогооны барилгын ажил”-ын эрхийг 2017 оны 08 сарын 31-ний өдрийн тушаалаар эрх шилжүүлснээс тухайн онд хэрэгжих боломжгүй болж он дамжин хэрэгжих нөхцөл үүссэн байна. Мөн ЭМС-аас “Өндөр-Улаан сумын ЭМТ-ийн дулааны шугам Хотонт, Хангай сумын ЭМТ-ийн нам даралтын зуух шинэчлэх ажил”-ын эрхийг 2017 оны 11 сарын 14-ний тушаалаар шийдвэрлэсэн байна. Ингэж оны сүүлийн хагаст эрх шилжүүлж хугацаа алдсанаас **тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулах, тендер шалгаруулалт нь хүйтний улирал эхэлснээр тухайн онд хэрэгжих боломжгүй болж он дамжин хэрэгжих нөхцөл үүсэж,**

улмаар хийгдээгүй ажилд санхүүжилт олгох, зориулалтын бус зарцуулах зэрэг эрсдэлд хүргэж болзошгүй байна.

**Иймд орон нутагт эрх шилжүүлж байгаа ТАХ-ний асуудлыг оны эхний хагаст шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгааг УАГ-аар уламжлуулан холбогдох ТЕЗ нарт хүргүүлж байна.**

Эрх шилжүүлсэн, тендер шалгаруулалт зохион байгуулсан хугацааны талаар дэлгэрэнгүйг Хавсралт №2-оос үзнэ үү.

“Жаргалант сумын 75 ортой дотуур байрны барилгын шугам сүлжээ, халаалтын тогооны барилгын ажил” нь хүйтний улирал эхэлсэн тул 2017 онд хэрэгжих боломжгүй болж дараа онд хэрэгжүүлэхээр хийгдээгүй ажилд гүйцэтгэл гарган баталгаажуулж, санхүүжилтийг ТЕЗ-аас авсан бөгөөд гүйцэтгэгчид олголгүй аймгийн “Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн” дансанд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу байршуулсан байна.

### **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналыг орон нутгаас нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж хүргүүлсэн байна.
2. Шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.
3. ТАХ-ний хэрэгжүүлэх эрхийг орон нутагт шилжүүлэхдээ хугацаа алдсанаас тендер шалгаруулалт оройтож, төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.

### **УЛАМЖЛАХ САНАЛ:**

Орон нутагт эрх шилжүүлж байгаа ТАХ-ний асуудлыг оны эхний хагаст шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгааг УАГ-аар уламжлуулан холбогдох ТЕЗ нарт хүргүүлж байна.


**ХОЁРДУГААР БҮЛЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

**2.1. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.**

- *Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог журмын дагуу байгуулж, тендерийн баримт бичгийг хуулийн хугацаанд боловсруулсан байна.*

Архангай аймагт 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад БСШУС-аас эрх шилжүүлсэн 10, ЭМСайдаас эрх шилжүүлсэн 2 нийт 12 их засварын ажлын ХАА-г захиалагчаас ирүүлсэн албан бичгийн дагуу аймгийн ОНӨГазар

зориулалтын дагуу зохион байгуулсан байна. Дэлгэрэнгүйг Судалгаа №2-оос үзнэ үү.



Харин Эрүүл мэндийн сайдаас эрх шилжүүлсэн “багийн эмч нарт мотоцикл худалдан авах” ажлыг аймгийн ЭМГ-т харьцуулалтын аргаар зохион байгуулж хэрэгжүүлжээ.

Тендерт зарцуулсан хугацааг хууль журамд заасантай харьцуулж үзэхэд хуульд заасан хугацаанд зохион байгуулж тайлагнасан байна. Дэлгэрэнгүйг Судалгаа №2-оос үзнэ үү

| ХААА-ны арга | Тоо | Зарцуулсан хугацаа | Хуульд заасан хугацаа |
|--------------|-----|--------------------|-----------------------|
| Нээлттэй     | 5   | 35-45              | 75                    |
| Харьцуулалт  | 7   | 7-47               | 50                    |

- Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтуудыг холбогдох шаардлагын баримтлан боловсруулжээ.
- 2017 онд зохион байгуулсан бүх худалдан авах ажиллагаанд сонгон шалгаруулалтын аргыг зөв хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан дээрх бүх ХАА-г ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1 дэх заалт болон ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолыг үндэслэн тендер шалгаруулалтын журмыг зөв сонгон хэрэгжүүлсэн байна. Өмнөх аудитаар барааны төсөвт өртгийг 2 багц болгон тендер шалгаруулалтын аргыг сонгон хэрэгжүүлж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5<sup>1</sup> дахь заалтыг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлжээ.

<sup>1</sup> “... нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

Дээрх бүх тендерийн урилгыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайт болон өдөр тутмын “Өнөөдөр”, “Өдрийн сонин” зэрэг сонинд нийтлүүлж ил тод мэдээлсэн байна.

Архангай аймагт 2017 онд шинээр хэрэгжүүлэх улсын төсвийн эрх шилжсэн 12 арга хэмжээний ХАА-г аймгийн ОНӨГазар зохион байгуулсны үр дүнд нийт 94.0 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон байна. Дэлгэрэнгүйг Судалгаа 2-оос үзнэ үү.

Сангийн Сайдын 2016 оны 415 тушаалаар баталсан журмын 4.26<sup>2</sup>-д заасны дагуу санхүүжилт хийгдэх бөгөөд Сангийн яамнаас санхүүжилт олгодог тул дээрх тендерийн хэмнэлтийг орон нутагт зарцуулах боломжгүй байна.

- *Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнасан байна.*

Архангай аймгийн ТЕЗ-ийн 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалын баталсан журмын дагуу бэлтгэж, заасан хугацаанд хүргүүлсэн байна.

## **2.2. Төсөл арга хэмжээний зураг төсвийг холбогдох хууль журмын дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.**

- *Зураг төсвийг хэрэглэгчийн шаардлагад үндэслэн мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлжээ.*

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас эрх шилжүүлсэн 18 ТАХ-ээс шинээр хийх их засварын 12 ажлын зураг төсвийг орон нутагт эрх шилжүүлсний дараа зураг төсвийн 5 мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн хэрэгжүүлжээ. Дэлгэрэнгүйг Судалгаа №1-ээс үзнэ үү.

Мэргэжлийн байгууллагуудын нь “Зураг төсвийг ашиглагч болон захиалагч байгууллагын хүсэлтийг үндэслэн БХБ-ын сайдын 2005 оны 80 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын төсвийн суурь норм”, Дэд бүтцийн сайдын 2004 оны 176 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын цахилгаан, холбооны угсралтын төсвийн суурь норм”, ЗТБХБ-ын сайдын 2009 оны 263 дугаар тушаалаар батлагдсан “Хийснээр олгох нэг цагийн цалингийн жишиг тариф”, ЗТБХБ-ын сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын машин цаг ашиглалтын нэг машин цагийн жишиг үнэ”, “Барилгын технологийн тээврийн авто машины цагийн болон тонн километрийн жишиг үнэ болон Барилгын бүтээц эдлэлийн үнийн лавлах зэрэгт үндэслэн Барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 06 сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалаар батлагдсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн дагуу төсөвт өртгийг тооцоолсон” гэж зураг төсвийн өмнөх тайлбарт дурдсан байна.

- *Зураг төсөвт өөрчлөлт оруулах шаардлага гараагүй.*

2017 онд шинээр боловсруулж хэрэгжүүлсэн дээрх зураг төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.

<sup>2</sup> Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан, эрх шилжүүлж, аймаг, нийслэл, сум, дүүрэг худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын хувьд тухайн ТЕЗ-ийн хөрөнгө, оруулалт, их засварын дансаар дамжиж санхүүжилт хийгдэнэ. ТЕЗ орон нутгаас ирүүлсэн санхүүжилтийн материалыг ажлын 3 хоногт хянаж Сангийн яаманд хүргүүлнэ.

- Зохиогчийн хяналтыг гэрээний дагуу хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг дарга зураг төсөв боловсруулсан байгууллагуудтай “Зохиогчийн хяналтын гэрээ”-г байгуулан ажилласан бөгөөд хяналтыг гэрээний дагуу хэрэгжүүлсэн байна.

**2.3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс ТАХ-ний ашиглалтанд орох хугацаа хоцорсон байна.**

- Гүйцэтгэгч гэрээний үүргээ хэрэгжүүлэх ажиллах хүчин, техник хэрэгслээр хангагдсан эсэхэд захиалагчийн хяналтын инженерээс тухай бүр хяналт тавьж шаардлага хүргүүлж ажиллажээ.
- Зарим гүйцэтгэгч байгууллага гэрээний хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй, зураг төсөвт тусгасан зарим ажлыг гүйцэтгээгүй байна.

Архангай аймагт эрх шилжүүлсэн өмнөх онуудаас он дамжин хэрэгжиж ашиглалтанд орсон 2 арга хэмжээ, хэрэгжиж дуусаагүй 1 арга хэмжээ байна. Үүнд:

- Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох /Эрчим хороолол 76 айл/ ажлыг Монгол Дайван ХХК нь 797.9 сая төгрөгөөр гүйцэтгэж 2016.11.30 нд ашиглалтанд оруулахаар 2015.08.20-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд 2017 онд улсын комисс хүлээн авсан боловч ашиглаж эхлээгүй байна.
- Хангай сумын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилгын ажлыг 2,798.3 сая төгрөгөөр гүйцэтгэж 2016.08.31 ний өдөр ашиглалт оруулах гэрээг Мон инж эм жи” ХХК нь 2013.10.07-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд 2017.06.01-нд ашиглалтанд оруулахаар гэрээг сунгасан боловч 2017 оны 12 сарын 15-ны өдөр ашиглалтанд хүлээлгэн өгч гэрээгээр тохирсон хугацаанаас 195 хоногийн дараа ашиглалтанд оруулсан байна.
- Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл” инженерийн шугам сүлжээнд холбох ажил хэрэгжиж дуусаагүй байна.

Дээрх ТАХ-нүүдийн төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй боловч эхний 2 ажлыг гэрээний хугацаанаас хоцорч ашиглалтанд хүлээлгэн өгсөн бөгөөд 1 арга хэмжээг хүлээн авсан боловч ашиглаж эхлээгүй байна. Энэ нь гэрээний хэрэгжилтэнд тавих захиалагчийн хяналт сул байгаатай холбоотой гэж үзэж байна.

Гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг хүлээлгэн өгч санхүүжилтээ бүрэн авсан ч гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас шалтгаалж зураг төсөвт тусгасан ажил дутуу гүйцэтгэгдсэн байна.

Тухайлбал:

1. Төвшрүүлэх сумын 320 хүүхдийн сургуулийн сургуулийн спорт заалны барилгыг “Дэлгэр констракшн” ХХК БСШУЯ-тай гэрээ байгуулан гүйцэтгэж 2017 онд ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Гэвч зураг төсөвт тусгасан дээврийн ус зайлуулах хоолойг хийгээгүй байна. Түүнчлэн тус барилгын цахилгааны шугам гэмтэлтэйн улмаас таазанд бэхэлсэн гэрлийн шилнүүд амархан “шатдаг”, “буудаж” хагарсны улмаас сурагчдын толгой дээрээс унаж бэртээх эрсдэлтэй нөхцөл үүссэн талаар сургуулийн захирал тайлбар ирүүлсэн.



Төвшрүүлэх. Спортын заал 2018.03.19  
Дээврийн ус зайлуулах хоолой хийгээгүй байгаа нь

Гэрлийн шил “буудсан байдал”

2. Эрдэнэмандал сумын 100 хүүхдийн дотуур байрны их засварын гүйцэтгэгч “БГБС” ХХК нь зураг төсөвт тусгагдсан "Х5" буюу гал тогооны өрөө рүү гаднаас шууд орох хаалгыг засч сайжруулан будах ажлыг гүйцэтгээгүй байна.

Зураг төсөвт тусгасан ажлыг дутуу хийсэн гүйцэтгэгч нараар ажлыг гүйцээж хийлгүүлэх албан шаардлагыг ГБХБГ-т хүргүүллээ.

- Захиалагч зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгасан байна.
- Төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтаар бусаар зарцуулаагүй байна.

Аймгийн Төрийн сангийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын дансаар 2017 онд нийт 2,032.8 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгджээ. Үүнийг ТЕЗ-аар нэгтгэж харуулбал дараах байдалтай байна. Дэлгэрэнгүйг Судалгаа №3-аас үзнэ үү.

| ТЕЗ-ийн нэр | ТЕЗ-аас шилжиж ирсэн санхүүжилт /сая.төг/ | Зөвхөн гүйцэтгэгчид олгосон санхүүжилт /сая.төг/ | Хяналтын зардалд шилжүүлсэн | Зураг төсвийн үнэд шилжүүлсэн | Барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн | тайлбар                                                                     |
|-------------|-------------------------------------------|--------------------------------------------------|-----------------------------|-------------------------------|--------------------------------------|-----------------------------------------------------------------------------|
| БСШУС       | 998.7                                     | 901.4                                            | 9.4                         | 1.2                           | 86.7                                 | Гэрээнд заасны дагуу шилжүүлсэн.                                            |
| ЭМС         | 392.6                                     | 386.0                                            | 1.7                         | 0                             | 4.9                                  | Гэрээнд заасны дагуу шилжүүлсэн.                                            |
| БХБС        | 508.3                                     | 154.7                                            |                             |                               | 353.6                                | Ажлын гүйцэтгэл дутуу тул үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан. |
| ЗГХЭГ       | 133.2                                     | 133.2                                            | 0                           | 0                             | 0                                    |                                                                             |
| <b>Нийт</b> | <b>2032.8</b>                             | <b>1575.3</b>                                    | <b>11.1</b>                 | <b>1.2</b>                    | <b>445.2</b>                         |                                                                             |

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг тодруулбал:

- БСШУССайдаас эрх шилжүүлсэн “Жаргалант сумын 75 ортой дотуур байрны барилгын шугам сүлжээ, халаалтын тогооны барилга угсралтын ажил”-ыг гэрээт хугацаанд гүйцэтгэж дуусаагүй он дамжин хэрэгжих болсон тул санхүүжилтийн **83.2** сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан.
- Барилга хот байгуулалтын сайдаас эрх шилжүүлэн 2014 оноос хойш он дамжин хэрэгжиж буй Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл”-ийн ажлыг гэрээний хугацаанд ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй, ажлыг бүрэн гүйцэтгээгүй тул 2017 оны санхүүжилт **338.4** сая төгрөгийг аймгийн Төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.
- Үлдэх **23.6** сая төгрөг нь чанарын баталгаат хугацаанд гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохиролцсон барьцааны хөрөнгө байна.

**2.4. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аваагүй байна.**

- *Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд эрх, үүрэг хариуцлагыг бүрэн тусгасан.*

2017 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгч нартай байгуулсан бүх гэрээнд эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан боловч гэрээнд “... Санхүүжилтийг Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 27-ны өдрийн 290 дүгээр тушаалын дагуу холбогдох бичиг баримтыг үндэслэн олгоно” гэж хүчингүй болсон эрхзүйн баримт бичгийг мөрдөхөөр тусгажээ. Дээрх тушаалаар баталсан журам нь Сангийн сайдын 2016 оны 12 сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалаар хүчингүй болсон байна.

Түүнчлэн зарим гэрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6<sup>3</sup>-д заасан “барьцаа”-ны тухай асуудлыг тусгаж өгөөгүй нь чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл үүсч болзошгүй байна. Иймд зайлшгүй барьцаалах шаардлагатай ТАХ-ний тухайд тендерийн баримт бичиг, гэрээнд тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- *Захиалагч үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн байна.*
- *ТАХ-г улсын комисс хүлээн авсан боловч зарим гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байна.*

Тайлант онд хэрэгжсэн 12 арга хэмжээнээс дараах 5 ТАХ-ний гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээг дүгнээгүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.6<sup>4</sup>, 49.2.10<sup>5</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Булган сумын сургуулийн 80 ортой дотуур байрны гүйцэтгэгч “Эсгэл” ХХК
- Хайрхан сумын Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийг хүүхдийн цэцэрлэг болгон өөрчлөх” ажлын гүйцэтгэгч “Морьтон констракшн”,

<sup>3</sup> Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж байна.

<sup>4</sup> 46.1.6 “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”

<sup>5</sup> 49.2 “Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ. 49. 2.10 “Гэрээ дүгнэж бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг

- Эрдэнэбулган сумын 2-р сургуулийн их засварын гүйцэтгэгч “Есөн талст оргил констракшн” ХХК
- Өндөр-улаан сумын ЭМТ-ийн халаалтын шугам, Хотонт, Хангай сумын ЭМТ-ийн нам даралтын зуухны шинэчлэлийг гүйцэтгэгч “Эсгэл” ХХК
- Жаргалант сумын “75 ортой дотуур байрны барилгын инженерийн шугам сүлжээ, халаалтын тогооны барилга угсралтын ажил” гүйцэтгэгч “Марал инж” ХХК.

➤ *Зарим ТАХ-г гэрээний хугацаанд ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй хугацаа хэтэрсэн байна.*

Орон нутагт эрх шилжүүлсэн он дамжин хэрэгжиж байгаа дараах ТАХ-үүдийг гэрээний хугацаанд нь ашиглалт хүлээлгэн өгөөгүй байна.Үүнд:

| ТАХ-ний нэр                                                        | Төсөвт өртөг | Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа |            | Авсан санхүүжилт сая.төг | Улсын комисст хүлээлгэн өгсөн | Гүйцэтгэлийн хувь |
|--------------------------------------------------------------------|--------------|----------------------------------|------------|--------------------------|-------------------------------|-------------------|
|                                                                    |              | Эхлэх                            | Дуусах     |                          |                               |                   |
| Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох                     | 797.9        | 2015.08.20                       | 2016.08.20 | 628.0                    | 2016.11.30                    | 100%              |
| Хангай сумын 320 хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилга | 2882.1       | 2013.10.07                       | 2016.08.31 | 2787.4                   | 2017.                         | 100%              |
| Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл”                               | 4794.0       | 2013.                            | 2015       | 4459.2                   | Ашиглалтанд ороогүй.          | 93%               |
|                                                                    | 6852.1       |                                  |            | 7874.2                   |                               |                   |

- *Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.*
- *Гэрээний хугацаа хоцроосон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хариуцлага тооцож ажиллаагүй байна.*

Хангай сумын 320 хүүхдийн сургуулийн хичээлийн байр, спорт заалны барилгын ажлыг гүйцэтгэгч “Мон инж эм жи” ХХК нь захиалагч 2013 оны 10 сарын 07-ний өдөр гэрээг байгуулж 2017.06.01-ний өдөр ашиглалтанд оруулахаар гэрээг сунгасан боловч улсын комисст 2017.12.15-нд буюу гэрээт хугацаанаас 195 хоног хоцорч ашиглалтанд хүлээлгэн өгсөн байхад гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй. Гүйцэтгэгч нь барилга байгууламжийн хувийн хэргийг захиалагч болон ашиглагч талд хүлээлгэн өгөөгүй байна.

Иймд дээрх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу алданги тооцож төсөвт төвлөрүүлэх, гэрээний үүргээ биелүүлээгүй тул хариуцлага ногдуулах арга хэмжээ авах талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг эргэж тайлагнах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлээд байна.

**2.5. Зарим ТАХ бүрэн хэрэгжиж ашиглалтанд ороогүй тул санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.**

- Аймгийн Төрийн сангийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын дансаар 2017 онд нийт 2,032.8 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгджээ. Үүнээс 1,575.3 сая төгрөгийг төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд үндэслэн Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д заасан баримт материалыг бүрэн бүрдүүлж, холбогдох маягтыг бөглөгдсөний дараа хянаж гүйцэтгэгч нарт олгосон байна. Харин гүйцэтгэл дутуу ажлын санхүүжилт болох 421.6 сая төгрөгийг аймгийн Хөрөнгө оруулалтын барьцааны дансанд шилжүүлсэн байна. Мөн гэрээгээр тохирсон чанарын баталгаа хугацаа дуустал гүйцэтгэгчийн үүргээ хэрэгжүүлэх баталгаа болгож 23.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна. дэлгэрэнгүйг Хавсралт №3-аас үзнэ үү.

**Дүгнэлт**

1. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна.
3. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байна.

**Зөвлөмж**

1. Цаашид улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6-д заасан “Барьцаа”-ны тухай асуудлыг тусгаж, гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд оруулж өгөх
2. Гүйцэтгэгч бүрээр гэрээний хугацаа дууссан үед гэрээний хэрэгжилтийг дүгнэж холбогдох арга хэмжээг авч, жилд 2 удаа олон нийтэд мэдээлж байх.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ АШИГЛАЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААС БИЙ БОЛОХ БОДИТ ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.**

**3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.**

- *Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон комисс зохих журмын дагуу хүлээн авсан.*

Орон нутагт эрх шилжүүлж 2017 онд шинээр хэрэгжүүлсэн 12 ТАХ-ээс 11 ажлыг улсын комиссын актаар байнгын ашиглалтанд хүлээн авсан ба 1 ажил дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Ашиглалтанд орсон ТАХ-ний жагсаалтыг Хавсралт №4-өөс үзнэ үү.

Мөн он дамжин хэрэгжиж буй дараах 2 ажлыг 2017 онд улсын комисс хүлээн авсан байна.

| ТАХ-ний нэр                                                               | Хуулийн код  | Төсөвт өртөг /сая.төг/ | Шалгарсан төсөвт өртөг /гэрээний дүн сая.төг/ | Улсын комиссын актын дугаар |
|---------------------------------------------------------------------------|--------------|------------------------|-----------------------------------------------|-----------------------------|
| Эрчим хорооллын цэвэр бохир усны гол шугам, 76 өрхийн салбар шугамын ажил | XI.1.8       | 3970.0                 | 3970.0                                        | БАО-2016/18                 |
| Хангай сумын 320 хүүхдийн хичээлийн байрны барилга угсралтын ажил         | XII.1.1.47.1 | 2882.1                 | 2882.1                                        |                             |

Харин эрхийг нь оны сүүлд шилжүүлсэнээс хугацаа алдсан мөн он дамжсан дараах 2 ажил хэрэгжиж дуусаагүй, ашиглалтанд ороогүй байна.

| ТАХ-ний нэр                                                                       | Төсөвт өртөг | Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа |            | Авсан санхүүжилт сая.төг | Гүйцэтгэлийн хувь |
|-----------------------------------------------------------------------------------|--------------|----------------------------------|------------|--------------------------|-------------------|
|                                                                                   |              | Эхлэх                            | дуусах     |                          |                   |
| Сумын төвийн шинэчлэл                                                             | 4794.0       | 2014.07.01                       | 2016.08.01 | 4459.2                   | 93%               |
| Жаргалант 75 ортой дотуур байрны барилгын шугам сүлжээ, халаалтын тогооны барилга | 273.1        | 2017.11.05                       | 2017.12.31 | 184.9                    | 68%               |
|                                                                                   |              |                                  |            | 4644.1                   |                   |

- *Байнгын ашиглалтанд хүлээн авсан ТАХ нь ашиглалтын явцад чанарын доголдол, эвдрэл гэмтэл гарсаар байна.*

Орон нутагт эрх шилжүүлж хэрэгжүүлэн 2017 онд байнгын ашиглалтанд хүлээн авсан 13 ТАХ-үүдээс Эрчим хорооллын цэвэр, бохир усны гол шугам, 76 өрхийн салбар шугамын ажлаас бусад ТАХ нь бүрэн ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалтанд хүлээн авснаас хойш зарим ТАХ нь чанарын доголдол гарсан, ашиглалтын явцад гэмтсэн талаар ашиглагчдаас гомдол тайлбар ирүүлсэн байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас үзнэ үү.

Иймд ашиглагчийн гомдлыг барагдуулах дутуу ажлыг гүйцээх, гэмтлийг завсарлуулах арга хэмжээг гүйцэтгэгч нараар хийлгүүлэх тухай хугацаатай албан шаардлагыг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч аймгийн ГХБХБГ-т хүргүүлээд байна.

- *Зарим ТАХ-а улсын комисс хүлээн авсан боловч ашиглагчийн бүртгэл тайланд тусгаагүй, ашиглаж эхлээгүй байна.*

2017 онд байнгын ашиглалтанд хүлээн авсан ТАХ-ээс Эрчим хорооллын цэвэр, бохир усны гол шугам, 76 өрхийн салбар шугамын ажлаас бусад ТАХ нь бүрэн ашиглагдаж ашиглагчийн нягтлан бодох бүртгэл тайланд бүрэн тусгасан байна. Харин Эрчим хорооллын 76 айл өрхийг цэвэр бохир усны шугамд холбох ажлыг улсын комисс хүлээн авсан боловч ашиглагч орон нутгийн өмчит “Ар ус Ундарга” ХХК-ний нягтлан бүртгэл, тайланд тусгаагүй, ашиглаж эхлээгүй байна. Орон нутгийн өмчийн газар, ашиглагч “Ар ус Ундарга” ХХК-ний ирүүлсэн тайлбараар “Салбар шугамд 76 өрх бүрэн холбогдсон боловч тухайн өрхүүд ашиглах бэлтгэлээ хангаагүй хэрэглэгчийн тоо хангалтгүй байгаагаас ашиглаж эхлээгүй” бөгөөд 2018 оны 05 сарын 01-нээс ажиллуулж эхлэхээр төлөвлөсөн байна.

**3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд аймгийн Засаг даргаас дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.**

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд аймгийн ТЕЗ-ийг төлөөлж аймгийн ГХБХБГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. 2017 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сан, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэлд аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба болон ЗДТГ-аас дотоодын хяналт шалгалт хийгдээгүй байна.

/Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын 2018.04.16-ны өдрийн 03/472 тоот албан бичиг, аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2018.04.13-ны өдрийн 46 тоот албан бичиг/

**3.3. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилт удааширснаас ашиглалтанд орох хугацаа хойшилж, хүртэх үр дүн үр ашиг хүлээгдсээр байна.**

- Хөрөнгө оруулалтын зарим ТАХ-ний бодит үр өгөөж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

| ТАХ-ний нэр                  | Төсөвт өртөг | Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа |            | Авсан санхүүжилт сая.төг | Гүйцэтгэлийн хувь |
|------------------------------|--------------|----------------------------------|------------|--------------------------|-------------------|
|                              |              | Эхлэх                            | дуусах     |                          |                   |
| <b>Сумын төвийн шинэчлэл</b> | 4794.0       | 2014.07.01                       | 2016.08.01 | 4459.2                   | 93%               |

Барилга хот байгуулалтын сайдаас эрх шилжүүлэн 2014 оноос хойш он дамжин хэрэгжиж буй Тариат сумын “**Сумын төвийн шинэчлэл**”-ийн ажлыг гэрээний хугацаанд ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй, гүйцэтгэгч “Эх голомтын илч” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй буруутай үйл ажиллагааны улмаас ашиглалтанд орох хугацаа хойшилсоор байна. Иймд дээрх төсөл арга хэмжээг яаралтай ашиглалтанд оруулах талаар мэргэжлийн байгууллагууд холбогдох арга хэмжээ авч ажиллах саналыг УАГ-аар уламжлуулан Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлж байна.

Ингэснээр орон нутагт улсын төсвийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжих ТАХ-ний үр дүн, үр ашгийг иргэд шуурхай хүртэж, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөсөн үр өгөөж хангагдах юм.

Энэ ТАХ-ний тухайд 2015 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар хийгдээгүй ажилд 1308.5 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан зөрчил илэрснийг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрөөгүй тул хөндлөнгийн мэргэжлийн шинжээч ажиллуулж бодит гүйцэтгэл, санхүүжилтийг гаргуулж холбогдох арга хэмжээ авахуулах саналыг аймгийн Аудитын газраас тайлангаар УАГ-т уламжилж байсан болно.

- *Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж үрэлгэн зарцуулаагүй.*

Орон нутагт эрх шилжүүлэн 2017 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн тухайд төсөвт өртгийг нэмэгдүүлж зарцуулсан зөрчил илрээгүй.

### **Дүгнэлт**

1. Улсын комисс байнгын ашиглалтанд хүлээн авсан зарим ТАХ-г ашиглагчийн бүртгэл, тайланд тусгаагүй байна.
2. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд аймгийн Засаг даргаас дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
3. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилт удааширснаас ашиглалтанд орох хугацаа хойшилж хөрөнгө оруулалтаас хүртэх үр дүн үр ашиг хүлээгдсээр байна.

### **Зөвлөмж**

1. Улсын комиссын актаар байнгын ашиглалтанд хүлээн авсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ашиглалтын байдалд аймгийн Засаг даргын дотоод хяналт шалгалтыг жилд 1 удаа хийж төлөвлөгдсөн хүчин чадлаар бүрэн ашиглах, олон нийтийн хүртэх үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, олон нийтийг тайлан мэдээллээр хангах

### **ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Аймгийн Аудитын газраас өмнөх онд хэрэгжүүлсэн аудитын дүнгээс 2 албан шаардлагыг аймгийн ГХБХБГ, ОНӨГ-т хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Харин аймгийн Засаг даргад хүргүүлсэн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан тухай хариу ирүүлсэн боловч бодит байдал дээр дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Тухайлбал:

- Гэрээний хугацаа дууссан үед гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж холбогдох арга хэмжээг авч байх

- Захиалагчийн хяналтыг сайжруулах, Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.1-5.6 дахь заалтуудыг чанд мөрдөж ажиллах

### **ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Урт болон дунд хугацааны төлөвлөгөөг үндэслэн ТАХ-г төлөвлөсөн боловч эрх шилжүүлэх хугацаа алдсанаас зарим ТАХ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
3. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг ашиглаж эхлээгүй байгаа нь хөрөнгө оруулалтаас бий болох бодит үр өгөөжийг бууруулж байна.
5. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх таслан зогсооход чиглэсэн 797.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг сайжруулахад чиглэсэн 3 зөвлөмжийг аймгийн ТЕЗ-д хүргүүллээ. Мөн холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх 2 саналыг ҮАГ-т уламжиллаа.

### **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн засаг дарга Ц.Мөнхнасанд

1. Цаашид улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6-д заасан “Барьцаа”-ны тухай асуудлыг тусгаж, гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд оруулж өгөх
2. Гүйцэтгэгч бүртэй байгуулсан гэрээний хугацаа дууссан тухай бүрд гэрээний хэрэгжилтийг дүгнэж холбогдох арга хэмжээг авч байх, гэрээний хэрэгжилтийн дүнг жилд 2 удаа олон нийтэд мэдээлж байх.
3. Улсын комиссын актаар байнгын ашиглалтанд хүлээн авсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ашиглалтын байдалд аймгийн Засаг даргын дотоод хяналт шалгалтыг жил бүр хийж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тухайн ТАХ-ний төлөвлөгдсөн хүчин чадлыг бүрэн ашиглах, олон нийтийн хүртэх үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн тайлан, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж байх

**Уламжлах санал:**

Аудитын явцад ажиглагдсан зүйл, аудитын дүнд үндэслэн дараах асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний эрхийг орон нутагт шилжүүлэхдээ тухайн оны эхний хагаст шийдвэрлэж байх саналыг ТЕЗ нарт уламжилж өгнө үү.

Ингэснээр ТАХ-ний хэрэгжилт удаашрах, он дамжин хийгдэх, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгох, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах зэрэг эрсдлийг бууруулах боломжтой юм.

2. Барилга хот байгуулалтын сайдаас эрх шилжүүлэн 2014 оноос хойш он дамжин хэрэгжиж буй Архангай аймгийн Тариат суманд хэрэгжиж буй **“Сумын төвийн шинэчлэл”**-ийн ажлыг гүйцэтгэгч “Эх голомтын илч” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй буруутай үйл ажиллагааны улмаас ашиглалтанд орох хугацаа хойшилсоор байна. Иймд дээрх төсөл арга хэмжээг яаралтай ашиглалтанд оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах саналыг Барилга хот байгуулалтын яаманд уламжилж өгнө үү.

Үүний үр дүнд хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөсөн үр өгөөж хангагдах улмаар аудит хийсний үр өгөөж, үр нөлөө олон нийтэд тодорхой болно.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аудитын тайлангийн төслийг Засаг даргад 2018.04.27-ны өдрийн 97 тоот албан бичгээр хүргүүлж тайланд саналаа ирүүлэхийг хүссэн боловч Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-д заасан хугацаанд хариу ирүүлээгүй болно. Иймд ямар нэгэн саналгүй гэж үзэн аудитын тайланг Тэргүүлэх аудиторын 2018 оны 05 сарын 04-ны өдрийн А/14 дугаар тушаалаар баталгаажууллаа.



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/Н

Цацарлаг

Гүйцэтгэлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1 дэх заалт, 2016 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2018 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газарт цаасаар болон файлаар мөн аймгийн ИТХ, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Нэргүйбаатар/-т даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын  
дарга, Тэргүүлэх аудиторын 2018 оны 2-сарын  
04-дрийн 4/4 тушаалын ... Хавсралт № 1

**Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт**

Аудитын нэр: Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Аудитын код: УАГ-ГАГ/2018/01-ГА

/сая.төг/

| № | Аудитаар илэрсэн<br>Зөрчлийн агуулга                                                                                                                                                                                                                           | Зөрчлийн<br>дүн /сая<br>төгөг/ | Өгсөн албан<br>шаардлага |                    | Тавьсан акт |                    | Өгсөн<br>зөвлөмжийн<br>тоо | Үр өгөөж |               |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------|--------------------|-------------|--------------------|----------------------------|----------|---------------|
|   |                                                                                                                                                                                                                                                                |                                | Тоо                      | Дүн /сая<br>төгөг/ | Тоо         | Дүн /сая<br>төгөг/ |                            | Тоо      | Мөнгөн<br>дүн |
| 1 | Зураг төсөвт тусгасан ажлыг дутуу гүйцэтгэсэн, ашиглалтын<br>явцад чанарын шаардлага хангахгүй, гэмтэл, эвдрэл гарсан,<br>гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй.                                                                         |                                | 1                        |                    |             |                    |                            | 1        |               |
| 2 | Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж ашиглалтанд хүлээн<br>авсан төсөл арга хэмжээг ашиглагчийн бүртгэл тайланд<br>тусгуулаагүй Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх заалт, Сангийн<br>Сайдын 2016 оны 415 тушаалаар баталсан журмын 6.1 дэх<br>заалтуудыг зөрчсөн. | 797.4                          | 1                        | 797.4              |             |                    |                            | 1        | 797.4         |
| 3 | Захиалагчийн хяналт хангалтгүйгээс зураг төсөвт тусгасан<br>ажлыг дутуу хэрэгжүүлсэн, гэрээний үүргээ хугацаандаа<br>хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарт гэрээг дүгнэж хариуцлага<br>тооцоогүй ТБОНӨХБАУХАТХ-ийн 46.1.6, 49.2.10 дахь<br>заалтуудыг зөрчсөн.        |                                |                          |                    |             |                    | 3                          | 1        |               |
|   | Нийт дүн                                                                                                                                                                                                                                                       | 797.4.06                       | 2                        | 797.40             | 0           |                    | 3                          | 3        | 797.40        |

Хавсралт №1

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Архангай аймагт 2017 онд эрх шилжүүлсэн  
төсөл арга хэмжээний жагсаалт

| №         | ТЕЗ   | Төсөл арга хэмжээний нэр                                                                                                                                | Хуулийн код      | Төсөвт өртөг | 2017 онд санхүүжих дүн /сая.төг/ | Ангилал   |
|-----------|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|--------------|----------------------------------|-----------|
| 1         | ЭМС   | Архангай Төрөх эмнэлэгийн засвар / Архангай Эрдэнэбулган сум/                                                                                           | XVI.2.1.1        | 300.0        | 284.2                            | Их засвар |
| 2         | ЭМС   | Архангай аймгийн Хотонт, Хангай сумын Эрүүл мэндийн төвийн даралтын зуух шинэчлэх, Өндөр-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн дулааны шугамын засварын ажил | XVI.2.1.2        | 45.0         | 44.6                             | Их засвар |
| 3         | ЭМС   | Архангай аймгийн Төрөх эмнэлэгийн барилгын А,Б блокуудын дотор засварын шинээр хийх ажил                                                                | XVI.2.1.3        | 53.0         | 53.0                             | Их засвар |
| 4         | ЭМС   | Архангай аймгийн 5 сумын 6 багийн эмчид мотоцикл худалдан авах                                                                                          |                  | 10.8         | 10.8                             | Их засвар |
| ЭМС-н дүн |       |                                                                                                                                                         |                  | 408.8        | 392.6                            |           |
| 5         | БСШУС | Архангай аймгийн Батцэнгэл сумын сургуулийн их засвар                                                                                                   | XII.1.2.1.1.67.а | 200.0        | 184.3                            | Их засвар |
| 6         | БСШУС | Сургуулийн дотуур байрны хаалга, цонхны засвар /Архангай, Эрдэнэмандал сум/                                                                             | XII.1.2.1        | 55.0         | 52.8                             | Их засвар |
| 7         | БСШУС | Сургуулийн дотуур байрны хаалга, цонх барилгын гадна дотор засвар /Архангай, Булган сум/                                                                | XII.1.2.1        | 85.0         | 79.8                             | Их засвар |
| 8         | БСШУС | Сургуулийн спорт заалны шал засвар /Архангай, Өлзийт сум/                                                                                               | XII.1.2.1.1.65   | 54.1         | 47.0                             | Их засвар |
| 9         | БСШУС | Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар өөрчлөн засварлах ажил                   | XII.1.2.1.1.67.б | 30.0         | 27.4                             | Их засвар |
| 10        | БСШУС | 2 дугаар сургуулийн барилгын засвар /Архангай, Эрдэнэбулган сум/                                                                                        | XII.1.2.1.1.70   | 170.0        | 157.98                           | Их засвар |
| 11        | БСШУС | Хөгжимт драмын театрын засварын ажил /Архангай, Эрдэнэбулган сум/                                                                                       | XII.1.2.1.1.68   | 50.5         | 49.99                            | Их засвар |

|    |       |                                                                                                                   |                |          |          |                            |
|----|-------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------|----------|----------------------------|
| 12 | БСШУС | Цэцэрлэгийн барилгын халаалтын тогоо барилга шугам засвар /Архангай, Төвшрүүлэх сум/                              | XII.1.2.1.1.69 | 65.0     | 61.6     | Их засвар                  |
| 13 | БСШУС | Сургуулийн 75 ортой дотуур байрны барилгын шугам сүлжээ, халаалтын тогоо угсралтын ажил /Архангай, Жаргалант сум/ | XII.1.1.47.1   | 302.0    | 273.1    | Их засвар                  |
| 14 | БСШУС | Хангай сумын 320 хүүхдийн суудлатай сургуулийн хичээлийн байр                                                     | XII.1.1.11     | 94.7     | 94.7     | Барилга угсралт он дамжсан |
| 15 | БСШУС | Хоршоолол сургууль цэцэрлэгийн их засвар                                                                          |                | 196.2    | 56.2     | Их засвар                  |
|    |       | БСШУС-ийн дүн                                                                                                     |                | 1,302.5  | 1,084.9  |                            |
| 16 | БХБС  | Эрчим хорооллын цэвэр бохир усны гол шугам, 76 өрхийн салбар шугамын ажил                                         | XI.1.8         | 797.9    | 169.9    | Барилга угсралт он дамжсан |
| 17 | БХБС  | "Сумын төвийн шинэчлэл"Архангай Тариат сум                                                                        | XI.1.47        | 4,794.0  | 338.4    | Барилга угсралт он дамжсан |
|    |       | БХБС-н дүн                                                                                                        |                | 5,591.9  | 508.3    |                            |
| 18 | ЗХЭГ  | Хашаат сумын ЗДТГ-ын барилга угсралт                                                                              | IV.1.3         | 943.2    | 133.2    | Барилга угсралт он дамжсан |
|    |       | БҮГД                                                                                                              |                | 8,246.40 | 2,118.99 |                            |

# АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт №2

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Архангай аймагт 2017 онд эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, хугацааны судалгаа

| Д/д | Хуулийн код     | Төсөл, арга хэмжээний нэр                                                                                                                               | ХАА-нд мөрдөгдсөн журам |                                    |              |            | ХАА-ны хэлбэр |    | Тендерт зарцуулсан хугацаа           |        |                                  |                                   |                                 |
|-----|-----------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|------------------------------------|--------------|------------|---------------|----|--------------------------------------|--------|----------------------------------|-----------------------------------|---------------------------------|
|     |                 |                                                                                                                                                         | Нэгдүгээр               | Тендер шалгаруулалтын онцгой журам |              |            | Цаас Цахим    |    | Үнэлгээний хороо байгуулсан тушаалын |        | Тендерийн урилга нийтэлсэн огноо | Гэрээ байгуулах эрх олгосон огноо | Зарцуулсан нийт хугацаа (хоног) |
|     |                 |                                                                                                                                                         |                         | Хягаар-лагдмал                     | Харилцуулалт | Шууд гэрээ |               |    | Огноо                                | Дугаар |                                  |                                   |                                 |
| А   | 2               | 3                                                                                                                                                       | 9                       | 10                                 | 11           | 12         | 13            | 14 | 15                                   | 16     | 17                               | 18                                | 19                              |
| 1   | XVI.2.1.1       | Архангай Төрөх эмнэлэгийн засвар / Архангай Эрдэнэбулган сум/                                                                                           | 1                       |                                    |              |            | 1             |    | 2017.04.26                           | а/161  | 2017.05.05                       | 2017.06.12                        | 38                              |
| 2   | XII.1.2.1.1.67a | Архангай аймгийн Батдунгал сумын сургуулийн их засвар                                                                                                   | 1                       |                                    |              |            | 1             |    | 2017.04.19                           | а/147  | 2017.04.24                       | 2017.06.09                        | 45                              |
| 3   | XII.1.2.1       | Сургуулийн дотуур байрны хаалга, цонхны засвар /Архангай, Эрдэнэмандал сум/                                                                             |                         |                                    | 1            |            | 1             |    | 2017.06.06                           | а/225  | 2017.06.08                       | 2017.07.08                        | 28                              |
| 4   | XII.1.2.1       | Сургуулийн дотуур байрны хаалга, цонх барилгын гадна дотор засвар /Архангай, Булган сум/                                                                | 1                       |                                    |              |            | 1             |    | 2017.05.25                           | а/201  | 2017.05.30                       | 2017.07.05                        | 35                              |
| 5   | XII.1.2.1.1.65  | Сургуулийн спорт заалны шал засвар /Архангай, Өлзийт сум/                                                                                               |                         |                                    | 1            |            | 1             |    | 2017.05.30                           | а/212  | 2017.06.07                       | 2017.07.03                        | 26                              |
| 6   | XII.1.2.1.1.67b | Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар өөрчлөн засварлах ажил                   |                         |                                    | 1            |            | 1             |    | 2017.08.15                           | а/351  | 2017.08.16                       | 2017.09.05                        | 20                              |
| 7   | XII.1.2.1.1.70  | 2 дугаар сургуулийн барилгын засвар /Архангай, Эрдэнэбулган сум/                                                                                        | 1                       |                                    |              |            | 1             |    | 2017.05.25                           | а/200  | 2017.05.30                       | 2017.07.17                        | 47                              |
| 8   | XII.1.2.1.1.68  | Хөгжимт драмын театрын засварын ажил /Архангай, Эрдэнэбулган сум/                                                                                       |                         |                                    | 1            |            | 1             |    | 2017.05.30                           | а/212  | 2017.06.07                       | 2017.06.22                        | 15                              |
| 9   | XII.1.2.1.1.69  | Цэцэрлэгийн барилгын халаалтын тогоо барилга шугам засвар /Архангай, Төвшрүүлэх сум/                                                                    |                         |                                    | 1            |            | 1             |    | 2017.05.30                           | а/211  | 2017.06.08                       | 2017.07.04                        | 26                              |
| 10  | XII.1.1.47.1    | Сургуулийн 75 ортой дотуур байрны барилгын шугам сүлжээ, халаалтын тогоо угсралтын ажил /Архангай, Жаргалант сум/                                       | 1                       |                                    |              |            |               | 1  | 2017.09.07                           | а/407  | 2017.09.18                       | 2017.10.25                        | 37                              |
| 11  | XVI.2.1.1       | Архангай аймгийн Хотонт, Хангай сумын Эрүүл мэндийн төвийн даралтын зуух шинэчлэх, Өндөр-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн дулааны шугамын засварын ажил |                         |                                    | 1            |            |               | 1  | 2017.11.27                           | а/525  | 2017.11.29                       | 2017.12.08                        | 10                              |
| 12  | XVI.2.1.1       | Архангай аймгийн Төрөх эмнэлгийн барилгын А,Б блокуудын дотор засварын шинээр хийх ажил                                                                 |                         |                                    | 1            |            |               | 1  | 2017.11.30                           | а/549  | 2017.12.01                       | 2017.12.07                        | 7                               |
| Дүн |                 |                                                                                                                                                         | 5                       |                                    | 7            | 0          | 10            | 2  |                                      |        |                                  |                                   |                                 |

Хавсралт №3

Архангай аймагт 2017 онд улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний нэгдсэн судалгаа

| № | ТЭЗ   | Төсөл арга хэмжээний нэр                                                                                                                                | Хэрэгжих хугацаа |        | Төсөвт өртөг | 2017 онд санхүүжүүлэх дүн | Гүйцэтгэгчийн нэр      | Бүгд          | аймгийн Төрийн сангаас 2017 онд олгосон санхүүжилт |                           |                          | Барцааны дансанд шилжүүлсэн |
|---|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|--------|--------------|---------------------------|------------------------|---------------|----------------------------------------------------|---------------------------|--------------------------|-----------------------------|
|   |       |                                                                                                                                                         | Эхлэх            | дуусах |              |                           |                        |               | Гүйцэтгэгчид олгосон                               | зурга төсийн үнэд олгосон | Хяналтын зардалд олгосон |                             |
| 1 | ЭМС   | Архангай Төрөх эмнэлгийн засвар / Архангай Эрдэнэбулган сум/                                                                                            | 2017             | 2017   | 300.0        | 284.2                     | Гураван тамир ХХК      | 284200000     | 279353677                                          |                           |                          | 4846323                     |
| 2 | ЭМС   | Архангай аймгийн Хотонт, Хангай сумын Эрүүл мэндийн төвийн даралтын зуух шинэчлэх, Өндөр-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн дулааны шугамын засварын ажил | 2017             | 2017   | 45.0         | 44.6                      | Эсгэл ХХК              | 44602617      |                                                    |                           | 779167                   |                             |
| 3 | ЭМС   | Архангай аймгийн Төрөх эмнэлгийн барилгын А,Б блокуудын дотор засварын шинээр хийх ажил                                                                 | 2017             | 2017   | 53.0         | 53.0                      | Гураван тамир ХХК      | 529999990     |                                                    |                           | 928390                   |                             |
| 4 | ЭМС   | Архангай аймгийн 5 сумын 6 багийн эмчид мотоцикл худалдан авах                                                                                          | 2017             | 2017   | 10.8         | 10.8                      | Нарны булан гэрэл ХХК  | 108000000     | 52071600                                           |                           |                          |                             |
